

ШАНХАЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНД ЗОЧЛОВ

2010 оны 11 сарын 11-13-ны өдрүүдэд Олон улс судлалын хүрээлэнгийн байранд Шанхайн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн дарга, Дэлхийн угсаатан, шашин, соёл судлалын төвийн захирал, Тайвань, Хонгконг, Макао судлалын хүрээлэнгийн профессор хатагтай Юй Синьтянь, Олон улсын стратеги судалгааны төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Ази Номхон далай судлалын төвийн захирал, доктор (Ph.D) Ма Ин, Эдийн засгийн харьцуулсан судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Ази Номхон далай судлалын төвийн орлогч захирал, дэлхийн Экспо төвийн орлогч захирал доктор (Ph.D) Гун Кеюй, Эдийн засгийн харьцуулсан судалгааны хүрээлэнгийн ажилтан Лю Жуни, доктор (Ph.D), дэд профессор Лян Дэгуй, Япон судлалын төвийн захирал, доктор (Ph.D) Ли Сюйши нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид хүрэлцэн ирж, албан ёсны айлчлал хийлээ. Төлөөлөгчдийг захирал, доктор Л.Хайсандай, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Д.Шүрхүү, Хятад судлалын секторын эрхлэгч, доктор Л.Бэгзжав нар хүлээн авч уулзав. Төлөөлөгчид манай хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай Монгол, Хятадын харилцаа, эдийн засаг улс төрийн хамтын ажиллагаа, гадаад бодлого зэрэг өргөн сэдвээр ярилцаж, сонирхсон сэдвээр санал солилцсон юм. Төлөөлөгчид Монгол Улсын Гадаад харилцааны яам болон судалгааны бусад байгууллагын албан хүмүүстэй уулзсан байна.

Шанхайн Олон улс судлалын хүрээлэнгийн талаар товчхон.

Хятад улсдаа төдийгүй дэлхийн хэмжээнд эхний шилдэг 10 think-tank-ийн нэг хэмээн тооцогддог Шанхай хотын захиргаанд харьяалагддаг Олон улс судлалын хүрээлэн (академи) 1960 онд байгуулагдсан. Энэхүү эрдэм шинжилгээний байгууллага нь өнөөдөр 90 орчим ажилтантайгаас 30 орчим нь тэргүүлэх зэргийн эрдэмтэн судлаачид байдаг байна. Судалгаа үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Хятадын гадаад харилцаа хийгээд дэлхийн улс төр, эдийн засаг, аюулгүй байдалд холбогдох стратеги, бодлого судлалын харьцуулсан судалгааны асуудал

- Олон улсын харилцааны чиглэлийн асуудлаар Шанхай хотын захиргаа, Төв Засгийн газарт санал, зөвлөмж хүргүүлэх

- Дотоод, гадаадын эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүдтэй хамтарсан судалгааны ажил, уулзалт семинар зохион байгуулах, эрдэмтэн судлаачид харилцан солилцох зэргээр харилцаа хамтын ажиллагаа хөгжүүлэх

- Төр засаг, хэвлэл мэдээлэл болон олон нийтэд дэлхий дахинд болж буй гол үйл явдал төдийгүй хөгжлийн чиг хандлагын талаарх ойлголт, мэдээ мэдээллээр хангах явдал ажээ.

Өнөөдөр энэхүү хүрээлэнгийн бүтцэд 6 хүрээлэн, 11 төв үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Олон улсын стратеги судлалын хүрээлэн
- Дэлхийн засаглал судлалын хүрээлэн
- Эдийн засгийн харьцуулсан судалгааны хүрээлэн
- Гадаад бодлого судлалын хүрээлэн
- Тайвань, Хонгконг, Макао судлалын хүрээлэн
- Мэдээлэл боловсруулалт болон судалгааны хүрээлэн
 - o Дэлхийн эдийн засаг судлалын төв
 - o Олон улсын байгууллага болон эрх зүй судлалын төв
 - o Өмнөд Ази судлалын төв
 - o Баруун Ази – Африк судлалын төв
 - o Ази – Номхон далай судлалын төв
 - o Орос болон Төв Ази судлалын төв
 - o Европ судлалын төв
 - o Америк судлалын төв
 - o Япон судлалын төв
 - o Дэлхийн угсаатан, шашин, соёл судлалын төв
 - o Олон улсын эмэгтэйчүүдийн харьцуулсан судалгааны төв багтдаг байна.

Хүрээлэнгийн эрдмийн зөвлөлд дээрх бүтцийн дарга, эрхлэгч нар багтах бөгөөд зөвлөхүүдээр нь Орос, Саудын Араб, Герман, Индонез, Энэтхэг, Швед, Солонгос, Америк, Япон, Аргентин, Өмнөд Африк зэрэг улсын эрдэмтэн судлаачид төдийгүй НҮБ, АСЕАН зэрэг олон улсын байгууллагын нэр хүндтэй судлаачид багтдаг байна.

Сард хоёр дугаар хэвлэгддэг “Дэлхий дахины тойм” (Global review) судалгааны сэтгүүлд хүрээлэнгийн судлаачдын эрдэм шинжилгээний бүтээл хэвлэгддэгээс гадна Олон улсын үйл явдлын (Survey of International Affairs) Судалгаа шинжилгээний ажлын зэрэгцээ 1979 оноос эхлэн Олон улсын улс төр судлалын чиглэлээр магистрын сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүрээлэнгийн Ерөнхийлөгч доктор Ян Земьянь нь Хятадын олон улс судлалын үндэсний холбооны дэд ерөнхийлөгч, Шанхайн Олон улс судлалын холбооны ерөнхийлөгч зэрэг албан тушаалыг давхар хашдаг байна. Тэрээр “Их тогтолцоо: олон туйлт ба олон оролцогч” (Grand System: Toward Multi-Polar & Multi-Actor, Tianjing People’s Publishing House, Tianjin, 2008), “Шилжилтийн үеийн олон улсын тогтолцоо ба Олон талт байгууллагын хөгжил” (International System in Transition and Multilateral Organization Developments, Shishi Publishing House, Beijing, 2007); “Их Интеррац: Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны чиг хандлага” (Grand Integration: Trends of Asian Economic Cooperation, Tianjing People’s Publishing House, Tianjin, 2007) зэрэг судалгааны олон бүтээл туурвисан нэр хүндтэй судлаач юм.

Хүрээлэнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.sis.org.cn хаягнаас үзнэ үү.

*Хэвлэлд бэлтгэсэн Д.Золбоо (ОУСХ-ийн эрдэм
шинжилгээний ажилтан, магистр)*